

SFA – «Малын гаралтай ширхэгт боловсруулах» стандарт хувилбар 2-ын талаарх оролцогч талуудын хэлэлцүүлэг

Танилцуулга: SFA-ийн «Цэвэр ноолуур боловсруулах» зохистой дадлын дүрэм (C003)-ийг SFA 2021 онд нийтэлсэн бөгөөд ноолуурын ямааны ноолуураас гарган авсан ширхэгтийн анхан шатны боловсруулалтыг хамардаг байв. Энэхүү дахин хяналтаар уг баримт бичгийн хамрах хүрээ өргөжиж, «Малын гаралтай ширхэгт боловсруулах» стандарт (цаашид «Стандарт» гэх) нэртэй болж байна. Түүнээс хойш SFA 2025 оны 1 дүгээр сард оролцогч талуудын өргөн хүрээний хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгээр ирүүлсэн санал, түүнчлэн стандартыг таван жил тутам дахин хянах тухай ISEAL-ийн зохистой дадлын дүрмийн шаардлагыг харгалзан энэхүү дахин хяналтыг эхлүүлсэн болно. Захиргааны нэгжийн үүргийг SFA гүйцэтгэж байгаа боловч брэнд, салбарын төлөөлөл, эрдэм шинжилгээний байгууллага болон Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-уудын төлөөллөөс бүрдсэн үндсэн ажлын хэсэг энэхүү дахин хяналтыг боловсруулахад оролцсон бөгөөд одоо 2026 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 60 хоногийн хугацаанд оролцогч талуудын өргөн хүрээний хэлэлцүүлэгт толилуулж байна. Үүний дараа ирүүлсэн саналд дүн шинжилгээ хийж, стандартыг шинэчилсний дараа, саналыг нэгтгэхэд томоохон бэрхшээл тулгарвал нэмэлтээр 30 хоногийн хугацаанд дахин хэлэлцүүлэг зохион байгуулна. Эцсийн шийдвэрийг SFA-ийн Стандартын тогтолцоог сайжруулах хороо (СТСХ) болон Удирдах зөвлөл гаргана. Хувилбар 2-ыг 2027 оны 02 дугаар сарын 28-ны өдөр нийтлэхээр төлөвлөж байна.

Та дараах асуултад хариулах замаар энэхүү хэлэлцүүлэгт оролцохыг урьж байна:

1. а) Хамрах хүрээний өргөтгөл – олон төрлийн амьтан SFA-ийн «Малын гаралтай ширхэгт» стандарт (AFS)-ын хамрах хүрээг тэмээний ноос болон сарлагын хөөврөөр өргөтгөх зорилтыг энэхүү дахин хяналтад харгалзан үзсэн бөгөөд үүнээс өмнө SFA холбогдох үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно. Малчин өрхүүд эдгээр малыг холимог сүргээр хамтад нь маллаж, ширхэгтийн боловсруулалтын ихэнхийг ижил төстэй нөхцөлд гүйцэтгэдэг нь нийтэд мэдэгдэж байгаа. Улмаар эдгээр мал амьтдыг өргөн хүрээнд ашиглан малчдын амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлэхэд чиглүүлдэг. Иймд AFS-ын өргөтгөсөн хамрах хүрээгээр баталгаажуулалт эхлэх үед бэлэн байх үүднээс Стандартын хамрах хүрээг ноолуурын ямаанаас гадна эдгээр амьтдыг эхний ээлжид хамруулан өргөтгөж байна. 

- ☐ Хамрах хүрээг өргөтгөхгүй
- ☐ Ноолуурын ямаа, тэмээ болон сарлагийг хамруулан өргөтгөх
- ☐ Нэг удаад нэг төрлийн амьтныг нэмж, үе шаттай өргөтгөх
- ☐ Бусад

2. б) Хамрах хүрээний өргөтгөл – хоёрдогч (гүн) боловсруулалт «Цэвэр ноолуур боловсруулах» стандарт хувилбар 1 нь зөвхөн анхан шатны боловсруулалтыг хамарч, ноолуурыг ангилах, хялгас ялгах, угааж цэвэрлэх үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байсан. Түүнээс цааш «Мөшгөлтийн тогтолцоо» стандарт нь нэгтгэх загварт суурилсан баталгаажуулалтыг тодорхойлж, нийлүүлэлтийн сүлжээний дагуух мөшгөлтөөр хэрэгжүүлж байв. Үүний улмаас тогтвортой байдлын стандартын шалгуурууд (хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, шударга хөдөлмөр, байгаль орчны менежмент, химийн бодисын хэрэглээ ба менежмент, сайн засаглал) хоёрдогч (гүн) боловсруулалтын үйлдвэрлэлийн хэсэгт хамрагдалгүй үлдэж, Стандартад тодорхой цоорхой үүссэн. Энэхүү дахин хяналтаар эдгээр шалгуурыг бэхжүүлэхийн зэрэгцээ хамрах хүрээг хоёрдогч (гүн) боловсруулалт хүртэл өргөтгөж байна (эцсийн бүтээгдэхүүнийг оёхыг хамруулаагүй – стандартын 13 дугаар хэсгийг үзнэ үү). Ингэснээр аж ахуйн нэгжүүд хүсвэл бусад стандартын баталгаажуулалтын тогтолцоотой «ижил түвшинд» хүрч гэрчилгээ авах боломжтой болно. Мөн энэ хувилбарт үйлчилгээгээ өргөтгөхийг хүсэж буй ТҮБ-уудад баталгаажуулалтын үйлчилгээний илүү олон боломж нээгдэнэ. Оролцогч талууд өмнө нь Стандартад хоёрдогч (гүн) боловсруулалтыг хамруулах талаар санал тавьж байсан. *

- ☐ Хамрах хүрээг хоёрдогч (гүн) боловсруулалтын хэсгээр өргөтгөхгүй
- ☐ Хамрах хүрээг стандартын 13 дугаар хэсэгт тусгасан хоёрдогч (гүн) боловсруулалтын хэсгээр өргөтгөх
- ☐ Бусад

3. Хэрэв стандарт нь хоёрдогч (гүн) боловсруулалтыг хамруулахгүй бол энэ нь нийлүүлэлтийн сүлжээнд тогтвортой байдал, мөшгөлт, чанар болон зах зээлийн нэмэлт эрсдэл үүсгэнэ гэж та үзэж байна уу? *

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Магадгүй
- ☐ Бусад

4. Хэрэв та 3 дугаар асуултад «Тийм» гэж хариулсан бол аль эрсдэл хамгийн их санаа зовоож байна вэ? (Тохирох бүх хариултыг сонгоно уу.)

- ☐ Мөшгөлт алдагдах

- ☐ Бүтээгдэхүүний талаар төөрөгдүүлсэн мэдэгдэл гаргах
- ☐ Химийн бодисын менежмент, зохистой ашиглалттай холбоотой эрсдэл
- ☐ Химийн бодисын бохирдол, зохистой менежментгүй бохир ус зайлуулалтаас үүдэх байгаль орчны эрсдэл
- ☐ Хөдөлмөрийн болон хүний эрхийн зөрчлийн эрсдэл
- ☐ Бүтээгдэхүүнийг орлуулах буюу хуурамчаар үйлдэх эрсдэл
- ☐ Хэрэглэгч болон зохицуулагч байгууллагын хүлээлтийг хангахгүй байх
- ☐ Нийлүүлэлтийн сүлжээний эрсдэл
- ☐ Market access risksЗах зээлд нэвтрэх эрсдэл
- ☐ Бусад

5. Хэрэв стандартын хамрах хүрээг хоёрдогч (гүн) боловсруулалтаар өргөтгөвөл аль шат хүртэл хамаарах ёстой вэ? *

- ☐ Зөвхөн ээрмэл утас үйлдвэрлэх шат хүртэл
- ☐ Даавуу үйлдвэрлэх шат хүртэл (нэхэх, сүлжихийг хамруулахгүй, харин будах болон эцсийн боловсруулалтыг хамруулна)

6. Мал амьтны ширхэгтийг дахин боловсруулахыг хувилбар 2-ын хамрах

хүрээнд оруулах SFA-ийн өмнөх хэлэлцүүлгүүдээс оролцогч талууд дахин боловсруулсан ширхэгт үйлдвэрлэхээр баталгаажуулалт авах сонирхолтой байгаа нь тодорхой болсон. Энэ нь нэхмэлийн салбарын эргэлтэт байдлыг дэмжиж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна. Гэвч ялангуяа хэрэглээний дараах ширхэгтийг дахин боловсруулах зорилгоор худалдан авах нь SFA-ийн гэрчилгээ, баталгаажуулалтын тогтолцоог хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой химийн бодис нэвтрэх зэрэг олон төрлийн эрсдэлд оруулж болзошгүй. Мөн зарлагдаагүй синтетик болон анхдагч түүхий эд нэвтрүүлэх оролдлогын магадлалыг нэмэгдүүлж, улмаар нийлүүлэлтийн сүлжээ болон хэрэглэгчийн хувьд зөрчил, тодорхойгүй байдлыг ихэсгэх эрсдэлтэй. Түүнчлэн энэ нь аудит, баталгаажуулалтыг төвөгтэй, үр дүн багатай болгодог. Иймд SFA нь хэрэглээний дараах дахин боловсруулах материалыг зөвхөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу олгосон гэрчилгээгээр нийлүүлж буй материалаа нотолж чадах нийлүүлэгчээс (Хавсралт 7-г

үзнэ үү), найрлагыг бүрэн зарласан, боловсруулалтын явцад мөшгөлтийн чанд шаардлагыг хангасан нөхцөлд худалдан авахаар тогтоож байна. Боловсруулалт өөрөө бүх үйл явцад хамаарах стандартын тогтвортой байдлын шаардлагад захирагдана. **Энэхүү дахин хяналтад мал амьтны ширхэгтийг дахин боловсруулах шаардлагыг оруулах ёстой юу?***

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Мэдэхгүй

7. Хэрэв дахин боловсруулалтыг хамруулах бол аль дахин боловсруулсан материалыг хамруулах ёстой вэ? (Тохирох бүх хариултыг сонгоно уу.)*

- ☐ Зөвхөн хэрэглээний өмнөх дахин боловсруулсан мал амьтны ширхэгт
- ☐ Зөвхөн хэрэглээний дараах болон хэрэглээний өмнөх дахин боловсруулсан мал амьтны ширхэгт
- ☐ Стандарт нь мал амьтны ширхэгтийг дахин боловсруулахыг хамрах ЁСГҮЙ
- ☐ Мэдэхгүй

8. Стандарт нь бусад төрлийн ширхэгт агуулсан, дахин боловсруулсан холимог ширхэгтийг мөн зөвшөөрөх ёстой юу?

- ☐ Тийм
- ☐ Үгүй
- ☐ Мэдэхгүй

9. Хэрэв дахин боловсруулсан холимог ширхэгтийг хамруулах бол аль холимгийг хамруулах ёстой вэ?*

- ☐ Мал амьтны ширхэгтийг байгалийн ургамлын болон мал амьтны гаралтай ширхэгттэй холисон (жишээ нь: хөвөн, маалинга, ангорын ноос)
- ☐ Мал амьтны ширхэгтийг нөхөн сэргээгдсэн целлюлозын ширхэгттэй холисон (жишээ нь: вискоз, лиоцелл)

- ☐ Мал амьтны ширхэгтийг синтетик ширхэгттэй холисон (жишээ нь: полиэстер, нейлон)
- ☐ Зөвхөн мал амьтны ширхэгт агуулсан бүх төрлийн холимог
- ☐ Бусад

10. Мал амьтны гаралтай бус бусад ширхэгтийг холих зөвшөөрөгдөх дээд хувь хэд байх ёстой вэ? *

- ☐ Дээд тал нь 5 хувь
- ☐ Дээд тал нь 15 хувь хүртэл
- ☐ Дээд тал нь 30 хувь хүртэл (стандартын Хавсралт 3-т нийцүүлэн)

11. Жижиг бизнесийн шалгуур үзүүлэлт Энэхүү дахин хяналтын хүрээнд нийлүүлэлтийн сүлжээн дэх жижиг бизнес эрхлэгчийн шаардлага хангах ачааллыг хөнгөвчлөх шалгуур үзүүлэлтийг судлах зорилготой. Гэвч дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгдсэн тодорхойлолт байхгүй бөгөөд дэлхийн өөр өөр орчинд харилцан адилгүй шалгуур үзүүлэлт мөрддөг (Хавсралт 4-ийг үзнэ үү). Иймд жижиг бизнес гэсэн мэдэгдэл гаргахыг хүсэж буй аж ахуйн нэгж нь үнэлгээ хийлгэх үедээ өөрт хамаарах шалгуур үзүүлэлтийн үндэслэлийг ТҮБ-д тайлбарлаж, зөвтгөхөөр энэхүү дахин хяналтаар тогтоож байна. *

- ☐ Тайлбарлахад ойлгомжгүй, зөрүүтэй, хоёрдмол утгатай байдал үүсэхээс сэргийлэхийн тулд SFA нь жижиг бизнесийг тодорхойлох стандарт шалгуур үзүүлэлтийг тодорхой заах ёстой.
- ☐ Ноорогт тусгасны дагуу SFA нь шалгуур үзүүлэлтийг нээлттэй үлдээх ёстой. Учир нь энэ арга нь олон улсын хэмжээнд мөрдөх стандартад илүү тохиромжтой.

12. Өөрийнхөө талаар бидэнд бага зэрэг мэдээлэл өгнө үү. Та дараахын алинд нь хамаарах вэ?

- ☐ Эрдэм шинжилгээ / судалгаа / багшлах
- ☐ Брэнд / худалдаа / жижиглэн худалдаа / тээвэр
- ☐ Хоршоо / боловсруулагч / үйлдвэрлэгч

- ☐ ТҮБ / ТҮБ-ын хяналтын байгууллага
- ☐ ТББ / буяны байгууллагын салбар
- ☐ Мэргэжлийн / салбарын холбоо
- ☐ Засгийн газар / орон нутгийн засаг захиргаа / зохицуулагч байгууллага
- ☐ Стандарт боловсруулагч байгууллага
- ☐ Их Британид байрлалтай
- ☐ Их Британиас гадна байрлалтай
- ☐ Монгол / Хятад / Балба / Азийн бусад улсад байрлалтай
- ☐ Европт байрлалтай